

## 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний нэгж, цэгүүдээр мэдээллийн самбар, цахим болон пэйж хуудсаар тогтмол мэдээлэл өгч, олон нийтэд зориулсан сурталчилгаа, соён гэгээрүүлэх материал байршуулсан. Олон нийтэд зориулсан сурталчилгаа, соён гэгээрүүлэх материалыг байгууллагын цахим хуудас болон харьяа нэгжүүдийн цахим, пэйж хуудсаар сурталчласан.

Тухайлбал:

**Говь-Алтай аймгийн УБХ:** Авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулж 80 гаруй иргэнд мэдээлэл, сурталчилгаа хийж гарын авлага, брошур тараалаа.

**Баян-Өлгий аймгийн УБХ:** 2022 оны 10-р сарын 19-ны өдөр Аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулсан авлига, гэмт хэргээс урьдчилах сэргийлэх сэдэвт сургалтад 18 албан хаагч хамрагдав. Байгууллагын нийт албан хаагчдад авлигыг тэвчих, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг өдөр тутмын үйл ажиллагаа, хэрэгцээ болгон ажиллах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй, хүнд сурталгүй хүргэж ажиллахыг үндсэн зорилго болгож ажиллахыг урилан ажиллаж байна. Мөн албан хаагчдад хэлтсийн дотоод цахим хуудсаар олон давтамжтай хүргэдэг.

**Булган аймгийн УБХ:** “Таны эрх, Таны оролцоо – Авлигад үгүй гэж хэлье” иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх өдөрлөг, “Илчилж авар”, “Цахим шилжилтэд хамтдаа”, “Шударга ёс, хөгжил дэвшилд” уриалга бүхий зурагт хуудас, гарын авлага, гомдол, мэдээлэл хүлээн авах утас -110 тусгай дугаарын танилцуулгыг хэлтсийн фэйсбүүк цахим пэйж хуудас, [Vulgan.burtgel.gov.mn](http://Vulgan.burtgel.gov.mn) сайтад байршуулсан мэдээллийг 16 сум, 1 тосгоны улсын бүртгэгч нар сумын ЗДТГ-н фэйсбүүк цахим пэйж хуудсаар дамжуулан нийт-4964 иргэнд, 2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр “Иргэний андгай” өргөх үйл ажиллагааг сумдын улсын бүртгэгч нар сумандаа зохион байгуулж 16 насанд хүрч иргэний үнэмлэхээ гардан авсан 75 хүүхдэд мэдээлэл түгээж ажиллалаа.

АТГ-ын Олон нийтийн төвөөс зохион байгуулсан “Авлига, түүний шалтгаан, нөхцөл, үр дагавар, авлигаас урьдчилан сэргийлэх арга зам, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх олон улсын туршлага” цахим сургалт, мөн “Ард түмэнд үйлчлэх зарчим ба авлига, ашиг сонирхлын зөрчил, шударга байдлын үнэлгээний үр дүн” сургалтад албан хаагчдаа хамруулсан. 2022 оны 01 дүгээр сарын 4-18-ны өдрүүдэд Тамгын газрын ахлах мэргэжилтэн Д.Мөнхтуяа, Нийслэлийн улсын бүртгэлийн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Ш.Сарангэрэл нар нийт 411 албан хаагчдад “ХАСХОМ хэрхэн бөглөх, анхаарах асуудлаар” сэдвээр цахим сургалт зохион байгуулсан. Шинээр томилогдсон 41 ажилтанд улсын бүртгэлийн хууль тогтоомж, дотоод журам, авлигаас урьдчилан сэргийлэх болон авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг, төрийн албаны болон улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ёс зүй, байгууллагын үйлчилгээний стандарт тус газрын бүтэц, чиг үүргийн тухай мэдлэг, мэдээлэл олгох сэдэвт 3 удаагийн сургалт зохион байгууллаа.